

МОНГОЛ ГЭР БҮЛИЙН ХҮҮХЭД ХҮМҮҮЖҮҮЛЭХ УЛАМЖЛАЛ*С.Солонго, ӨМБИС***Abstract**

This paper discusses the traditions experiences of Mongolian methods on children upbringing. We also want to pay attention on how it has been changed up to the present days. What mistakes have we done and what has been the most important for children`s breeding nowadays in the globalization era? It is certainly that the humanity has had a requirement to educate and bring up the children. We are the nations which have classical traditions inherited from the ancient time. In this article, we want to remind people to recall our great teachings and sayings related to the child upbringing.

Түлхүүр үг

Гэр бүл, хүүхэд, зан төлөв, уламжлал

Удиртгал

Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудал нь манай нийгмийн тулгамдсан асуудал юм. Тухайлбал, улсын хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2009 онд 46 мянгад хүрсний 4683 нь бүтэн өнчин хүүхэд байна. Өрх толгойлсон ээж 82 мянга болж өмнөх оноос 5.8 хувиар өссөн байна. Нийт 35 мянган хос гэрлэлтээ бүртгүүлсэн боловч 2,4 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэлт өмнөх оныхоос 3,3 хувиар, гэр бүл цуцлалт 27 хувиар өссөн байна. Үүнтэй зэрэгцэн, гэр бүлийн орлого муутайгаас хүүхэд хөдөлмөр эрхлэх, эцэг эхийн хараа хяналт сулаас хүүхэд сургууль завсардах, гадуур тэнэх, тоглоомд донтох, гэмт хэрэгт холбогдох зэрэг нийгмийн олон сөрөг үзэгдэл гарч, арга хэлбэр нь жилээс жилд нарийсаж байна.

Ийм нөхцөл байдалд хүүхдийг хүмүүжүүлэх төлөвшүүлэх асуудал улс орны хөгжлийн онцгой чухал хэсэг болох ёстой бөгөөд нийгэм, цаг үе, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогтой нягт уялдах учиртай юм. Бид энэхүү өгүүлэлд хүүхдийн хүмүүжилд уламжлалт болон орчин үеийн арга хандлагуудыг хослуулан үр хүүхдийнхээ зан төлөвт анхаарч, хүмүүжүүлэх талаарх эрдэмтдийн үзэл бодол, хандлагыг нэгтгэх зорилго дэвшүүллээ. Судалгааны хүрээнд Т.Намжилын “Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал”, “Гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх уламжлал”, Т.Бүрэнжаргал “Гэр бүлийн социологи”, Ш.Ичинхорлоо “Хүүхдийн хөгжил”, “Хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ” Тоо Вангийн Сургаал, Монголын Нууц Товчоо зэрэг бүтээлүүдэд шинжилгээ хийх, зөвлөмж өгөх зорилтуудыг дэвшүүлсэн.

Гэр бүл гэдгийн дор нэгдүгээрт, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хамтран амьдрах

холбоо⁸, хоёрдугаарт, сайн дурын үндсэн дээр баталгаажуулсан эрх зүйн харилцаа, гуравдугаарт, гишүүд нь нэгдмэл үнэт зүйлээр бэхэжсэн бүлэг, дөрөвдүгээрт, гэр бүлийн хосууд бэлгийн харилцаатай байдаг, тавдугаарт, хүүхэд төрүүлж, нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх хүсэл зорилготой зэрэг шинж чанар бүхий нийгмийн суурь бүрэлдэхүүнийг ойлгоно.

Хүн төрөлхтөн үүсэж бий болсон цагаасаа эхлэн залгамж хойч үр садаа зөв зан төлөв, хүмүүжилтэй болгохыг зорьсон нь дамжиггүй. Эдүгээ дэлхийн хүн төрөлхтөн маш сонирхолтой бөгөөд асар хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй цаг үед амьдарч байна. Хүмүүсийн амьдралын хэв маяг, улс орны хөгжлийн чиг хандлага салбар, хоорондын зах зээлийн төлөөх ширүүн өрсөлдөөн, мэдээллийн асар хурдтай хөгжил, шинэчлэл гээд нэрлэж барахгүй маш олон асуудлууд ар араасаа гарч байна.

Монголчууд бид хэдэн зууны тэртээгээс өртөөлөн ирсэн хүмүүжлийн сонгодог өв уламжлалтай ард түмэн билээ. Тухайлбал, МНТ-д Уруйд мэргэдийн дүрвэж дутаасны хойно тэдний нутаг дээр булган малгайт, марлын годон гуталт, жарх усны булга, хоёрыг зүүсэн нүдэндээ галтай нүүрэндээ цогтой Хүчү гэдэг нэртэй 5 настай хөвгүүн хоцорсныг олж ирж авчирч Өгэлүн эхэд бэлэг болгон өгөв (Монголын Нууц Товчоо, 2009, х.52)

Татаарын хоргодож байсан Нарату шүтээний нутаг дээр нэгэн өчүүхэн хүүхэд орхигдсоныг бидний цэргүүд олжээ. Үзвэл дөртэй алтан ээмэг зүүсэн ба булгаар доторлосон даж торгон элгэвч “хантааз” өмссөн ажээ. Тэр хүүхдийг Чингис хаан авчирч, Өэлүн эхэд

⁸Википедия*  soko_ami@icloud.com

бэлэг гэж өгөв. Өэлүн эх өгүүлрүүн: “Сайн хүний хөвүүн биз язгуур сайт хүний ураг биз” 5 хөвгүүний дараах 6-р хөвгүүн болгоё гээд Шигихутаг гэдэг нэр өгч асрав Тэднийг Өгэлүн эх өөрийн арга сургаалаар хүмүүжүүлж Чингис хааны өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгон хүмүүжүүлэв хэмээн Монголын Нууц Товчоо-д дурджээ. Үүнээс үзэхэд монгол үндэстэн аль XIII зууны үед л хүүхдийн 5-6 нас хүмүүжлийн хамгийн чухал эгзэгтэй үе гэдгийг олж тогтоож чадсан агуу баялаг уламжлалтай үндэстэн билээ. Оросын нэртэй сурган хүмүүжүүлэгч А.С.Макаренко “хүүхэд 5 хүртэлх насандаа зөв зан төлөвийн 90%-ийг олж авдаг” гэж бичсэн байдаг энэ дээрх жишээг баталсан мэт.

Монголчууд бид хэдэн зуун хуудастай ном бичиж, хадгалах боломж бололцоо байхгүй тэр эрт цагаас эхлэн хойч үеэ хүмүүжүүлэх үзэл сургаалаа хоёрхон мөр үгэнд багтаан хүүрнэж хүнээр хүн хийх арга ухаан, тэдний зан чанарт үеэс үед дамжуулан уламжилж ирсэн байдаг.

“Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа”, “Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг”, “Эзэн хичээвэл заяа хичээнэ”, “Ажил хийж хүн болдог, ар давж хүлэг болдог”, “Эрхийг сурахаар бэрхийг сур”, “Эх нь булингартай бол адаг нь булингартай”, “Биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал”, “Бие нь төрмөл, санаа нь таримал” гэх мэт утгачлан хэлэлцэж нас насанд нь тохирсон үг хэллэгийг үр хүүхдээ бага балчраас нь өрх гэртээ болон айл саахалтаараа хамтран зүй зохистой сурган хүмүүжүүлж ирсэн уламжлалтай ажээ.

“Бие нь төрмөл, санаа нь таримал” гэсэн цэцэн үгэнд хүнээр хүн хийх сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны зайлшгүйг батлахын хамт хүний хүмүүжил, зан төлөвт нийгмийн олон хүчин зүйлс, шинж чанар, орчин нөхцөл төлөвшүүлэх явдал амин чухал болохыг илэрхийлсэн зүйр үг байна. Өвөг дээдсээс минь хуримтлуулсан нийгмийн баялаг туршлагыг “байгалиас төрмөл биед” сургалт хүмүүжлээр дамжуулан өвлүүлэн эзэмшүүлсний үр дүнд нийгмээс “Таримал санаа” бодол бий болж төлөвшдөг гэсэн санаа байх юм.

Зан төлөвийн талаар маш олон эрдэмтдийн үзэл санаа тодорхойлолтууд байдаг. Эрдэмтэн судлаач Ш.Ичинхорлоо зан төлөвт сургах хүмүүжил хэмээх үзэгдлийг ийнхүү тодорхойлжээ (Ичинхорлоо, 2012). “Хүмүүжил бол эцэг эх хүүхдэдээ авьяас чадавхаа нээн хөгжүүлэх таатай нөхцөл бүрдүүлж, түүнд хүний эрхэм нандин зан чанарыг төлөвшүүлж улмаар сайн хүн болгох, зөв зан төлөвт сургах, төлөвшүүлэх бүтээлч арга ажилбар буюу хүүхдээр ХҮН хийх арга ухаан, бас урлаг гэж үзэж байна” хэмээн тодорхойлсон

байна. Ер нь аливаа улс орон, үндэстэн ястан өөрийн онцлог, хэв маяг, амьдралын зан дадал орчин нөхцөлөөсөө шалтгаалаад хүүхдийн зан төлөвт олон хэв маяг дадал хэрэгцээ, сэдэл зарчим зорилго, агуулга, арга хэрэглүүртэй нь дамжиггүй.

Тэгвэл бид өнөөдөр хүүхдээ хүмүүжүүлэхдээ юуг гол баримжаа болгож байна вэ? Хэн нэгийг даган далдганаж “Хэрээ галууг дагаж хөлөө хөлдөөв” гэдгийн үлгэрийг давтаж байгаа мэт заримдаа санагддаг аа нуух юун билээ. Бид бол дорнын соёлтой ард түмэн. Дорно дахины сурган хүмүүжүүлэх тэр дундаа Монгол уламжлал бол гэр бүлсэг, ах зах хүмүүс, эцэг эхийн нэр хүндийн төлөө гэх, зарим тохиолдолд албадлагын арга хэрэгсэл хэрэглэдэг. Харин өрнийхөн бол бараг эсрэгээрээ. Эрдэмтэн судлаач Ш.Ичинхорлоо ямар бүтээлд мөн номдоо “Өрнийн нөлөө улам ихсэж, түүнд дотор хүүхдийн зөв зан төлөвшихөд өрнийн үзэл санаа арга барил хүчтэй нэвтрэх болжээ. Энэхүү дорно дахины болон өрнийн тэс өөр үнэт зүйлс хоорондоо зөрчилдөх болж, энэ байдал нь эргээд хүүхдийн хүмүүжилд тийм сайнаар нөлөөлж байна гэхэд эргэлзээтэй хэмээн тэмдэглэжээ. Тэгвэл бидний өвөг дээдэс хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх ямар өв уламжлалыг бидэнд төрүүлсэн бэ? Бид ямар сургалтаар дамжин орчин үеийн хүмүүжил сургалтын системд хүрсэн бэ?

Монголын нэрт сэтгэгч соён гэгээрүүлэгч Тогтох төрийн 1735 онд зохиосон “Тоо вангийн 3 үсэгт” хэмээх номдоо⁹:

Номонд мэргэн, нойронд сэргэг

Үйлэнд уран, үгэнд цэцэн

Дайнд баатар, далайд усч

Хуульд шударга, хуримд цовоо

Дээдэд зусаргүй, доодод найртай эр хүний 10 эрдэм хэмээн хэлэлцдэг.

Мөн Тоть шувууны сургаалд хүүхдийг зөв зан төлөвтэй хүн болгон төлөвшүүлэхэд

Үнэн бат журам үргэлж сахиж явах

Өвөг дээдийн сургаалын санаж сэргэж явах

Үйлийн дээд ачийг буцааж хариулж авах

Өсөх гээхийн амьдралыг учирлан таньж явах

Үлэмж мэргэн номыг тогтоон тунгааж авах

Үзээгүй дорд ардыг өргөн тэнхрүүлж явах гэж сургадаг байжээ. Мөн бид үр хүүхдээ хүмүүжүүлэхэд голлон анхаардаг бас нэг зарчим бол даган дуурилгаж сургаж хүмүүжүүлж ирсэн ард түмэн билээ.

⁹Тоо вангийн 3 үсэгт

Бидний үр хүүхдийн ямар хүн болох мэдээж маш олон зүйлээс шалтгаалах ч гэсэн хамгийн хамааралтай нь эцэг эх билээ. Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч В.А.Сухомлинский “Чи хүн болж төрсөн. Гэвч хүн шиг хүн болох ёстой” гэж хэлсэн байдаг нь монгол хүний сурган хүмүүжүүлэх ерөнхий зарчимтай тохирч байгаа юм. Өвөг дээдэс минь гэрийн сургалтаар хүүхдүүдээ гэр бүлийн орчинд зөв зан чанар, төлөвт сургахдаа дээр дурдсанчлан даган дуурайлгах, зүйр цэцэн үг хэллэгийг байнга тогтмол хэлж оюун ухаанд нь амьдралын нэрийн ухааныг суулгадаг байжээ (Бүрэнжаргал, 2005).

“Хүүхдийг багаас нь хатуу хүтүү арьс, ширмэл ширдэг дээр унтуулж биеийг нь чангаруулж 2-3 наснаас нь эхэлж хурга ишигний зүс нүдлүүлж, гар хөлийн үзүүрт хөдөлгөн, юм дөхүүлэх, ойртуулах зэрэг хүч чадалд нь тохирсон ажил хийлгэдэг байжээ. Хүүхэд хөдөлнө явна гэдэг бол хөдөлмөрлөх үндэс эхэлж байна гэсэн үг” гэж Т.Намжил тэмдэглэжээ. Өвөг дээдэс маань “Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал” гэж сургаж ажлыг дуустал хийлгэхийг эрмэлздэг байжээ. Аливаа ажлыг буруу хийвэл зодож, загнахгүйгээр учрыг сайн ойлгуулж тайлбарлах, хөдөлмөрийн сайхныг мэдрүүлэхийн тулд хөдөлмөрийн ач тусыг бодитойгоор үзүүлж өгөх нь бага насны хүүхдэд чухал байдаг. Ингэснээр зан төлөвт нь олон эерэг нөлөө үзүүлж ирсэн байна.

Дүгнэлт

Орчин үед хүүхдийн зан төлөв нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байна. Монголчуудын хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлал нь үр нөлөө, ач холбогдлоо алдаагүй байгаа нь орчин үеийн судлаачдын бүтээлд чухал байр суурь эзэлсээр байгаа нь харагдаж байна. Эцэг эхчүүдэд сэтгэл зүйн мэдлэг чадвар шаардлагатай байгааг орчин үеийн бүтээлүүдэд дурдсан байна. Хүний удам угсааг бий болгож хүнийг хүмүүжүүлж нийгмийн анхны нэгж болж байдаг хувьдаа гэр бүлийн хүмүүжил нь нийгмийн хүмүүжилд онцгой байр эзэлдэг. Гэр бүлийн хүмүүжил нь ялангуяа охид хөвгүүд, өсвөр үеийнхэнд ёс суртахууны хэм хэмжээг тогтоон бэхжүүлж, зөв төрх намба бүрэлдэн тогтоход тусалдаг. Үр хүүхэд бол эцэг эхээсээ зөвхөн эд хөрөнгө өвлөгчид биш. Эцэг эхийнхээ бүтээлч шаргуу хөдөлмөрөөр бүтээсэн өмч хөрөнгө, ахмад үеийнхээ эрхэм нандин зан чанарыг залгамжлан авагчид юм. Энэ утгаараа гэр бүлийн доторх ахмад хүмүүсийн нөлөө өсвөр үеийнхний хүмүүжилд асар их ач холбогдолтой. Эцэг эхийнх

нь ёс суртахуун сайн сайхан чанарууд үр хүүхдэд нь уламжлагдан үлддэг. Ийм нөлөөлөл байхгүй бол үр хүүхдийн хүмүүжил доголдол дутагдалтай болдог. Хүүхдийн зан байдал эвдэрсэн үед хэчнээн хэлээд үглээд ч нэмэр болох нь бага байдаг болохоор бага балчраас нь хүүхэдтэйгээ байнга сайн ажиллаж, ёс суртахууны ариун нандин хүмүүжилтэй болгоход онцгой анхаарах учиртай. Гэр бүлийн доторх хэрүүл маргаан, үнэнч шударга биш явдлыг хүүхэд ашигласнаас болоод хүүхэд хуурч мэхлэх, худал хэлэх, хэрүүл маргаан дэгдээхээс эхлээд ёс суртахууны элдэв гаж буруу явдал гаргахад хүрдэг. Энэ бүхнийг ялангуяа залуу шинэ гэр бүл бага гэхгүйгээр анхааран болгоомжилж үр хүүхдээ зөв сайхан хүмүүжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Гэрийн хүмүүжил нь өөрийн өвөрмөц аргатай, олон үеийн турш амьдралаар шалгагдсан, үндэсний онцлогоо хадгалсан шинжтэй, гэр бүлээр дамжуулан нийгмийн зан байдлын хэм хэмжээг дэс дараатай эзэмшүүлдэг ёс суртахууны тогтолцоо байжээ хэмээн дүгнэж болохоор байна.

Ашигласан материал

- Намжил, Т. (1996). Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар
- Намжил, Т. (2005). Гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх уламжлал. Улаанбаатар
- Бүрэнжаргал, Т. (2005). Гэр бүлийн социологи. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2010). Хүүхдийн хөгжил. Улаанбаатар
- Мөнхийн үсэг групп. (2009). Монголын Нууц Товчоо. Улаанбаатар: Admon